- D. Волкович-Дъяконовын зүслэг
- E. Вейерагийн зүслэг

/38./ Доорх тодорхойлолтуудыг харгалзуул

1. Хатиг
2. Мундас
3. Фолликулит
4. Гөгий
5. Флегмон

A. Тодорхой зааг хязгааргүй, өөхөн эслэгийн түгээмэл цочмог идээт үрэвсэл

B. Хурууны эдүүдийн идээт үрэвсэл

- С. Арьс халимын их хэмжээний үхжил бүхий олон тооны үсний уут, хөлс тосны булчирхайг хамарсан цочмог идээт үхжилт үрэвсэл
D. Үсний хүүдий, түүний орчны эд, хөлсний булчирхайг хамарсан цочмог идээт үрэвсэл
E. Зөвхөн үсний хүүдийгээр хязгаарлагдсан өнгөц үрэвсэл

- A. 1D,2C,3E,4B,5A
- B. 1B,2A,3D,4E,5C
- C. 1C,2D,3A,4B,5E
- D. 1E,2A,3C,4B,5D
- E. 1E,2C,3A,4B,5D

/39./ Гэдэсний цоорхойгоор гарч буй агуулагдахуун, шингэний хэмжээ хэд бол их хэмжээтэй гэж үзэх вэ?

- A. Хоногт 100мл
- B. Хоногт 500 мл
- C. Хоногт 1000 мл
- D. Хоногт 2000 мл
- E. Хоногт 3000 мл

/40./ Бэтэг хүний биед олон жил болж, улмаар тэр нь илэрч мэдэгдэх бөгөөд энэ үедээ уйланхайн гэр нь зузаарч, шохойжин хатуурах ба дотроо авгалдайнүүд бие даасан жижиг бүрхүүлийг үүсгэн олон цэврүүт бэтэг болох бөгөөд үүнийг:

- A. Шохойжсон бэтэг
- B. Бүрэн үхсэн бэтэг
- C. Хагас үхсэн бэтэг
- D. Хөгшин бэтэг
- E. Хоёрчлогдсон бэтэг

/41./ Хэт авиан шинжилгээнд бэтгийн ямар хэлбэр байгаагаас хамаарч дараахь хэлбэрээр харагдана. Тохируулан сонго. 1. Залуу бэтэг

- 2. Үр уйланхайгүй бэтэг
- 3. Хагас үхсэн бэтэг
- 4. Шохойжсон бэтэг
- 5. Идээлсэн бэтэг
- 6. Үхсэн бэтэг /бүрэн үхсэн бэтэг/
 - а. Зах хэсэгтээ үр уйланхайтай, голдоо нэг жигд эдтэй
 - б. Зузаан ханатай усан уйланхай мэт
 - в. Заримдаа цас будрах шинж илэрдэг
 - г. Шүхэр мэт сүүдэртэн харагдана.
 - д. Дүүрэн үр уйланхайтай, бүрхүүл нимгэн байх
 - е. Зузаарсан хунигдсан, хитин бүрхүүл хээ угалз мэт харагдана

- A. 1а 2б 3в 4г 5е 6д
- B. 1а 2в 3б 4д 5г 6е
- C. 1д 2б 3а 4г 5в 6е
- D. 1д 2а 3б 4е 5г 6в
- E. 1а2в3б4е5д6г

/42./ Чацархайн цусан хангамжийн цочмог ишемийн шалтгаан юу вэ?

- A. Артерийн эмболи
- B. Артерийн тромбоз
- C. Судасны спазм
- D. Венийн тромбоз
- E. Доод хөндийн венийн тромбоз

/43./ Панкреостаз гэж үзэх үндэслэл аль нь вэ?

- A. Хэвийн хэмжээнээс амилаза 2-4 дахин ихсэхийг
- B. Хэвийн хэмжээнээс амилаза 0,5 дахин ихсэхийг
- C. Хэвийн хэмжээнээс амилаза 0,5-1,5 дахин ихсэхийг
- D. Хэвийн хэмжээнээс амилаза 1000 дахин ихсэхийг
- E. Хэвийн хэмжээнээс амилаза 2-4 дахин багасахыг

/44./ Ходоодны цочмог суналтыг оношлох хамгийн сайн арга аль нь вэ?

- A. Ходоод дээрх гэдэс дурандах
 - B. КТГ
 - C. МРТ
 - D. Рентген тодотгогчтой харалт
 - E. Ходоодонд хаймсуур байрлуулж даралтыг хэмжих
- /45./ Хагалгааны дараахь хүндрэл, хагалгааны өмнөх ямар байдлаас хамаарах вэ?
- A. Шээсний гарцын байдлаас
 - B. Хуниас булчингийн агшилт шээсний урсгалд нөлөөлөх
 - C. Үлдэгдэл шээсний хэмжээнээс
 - D. Түрүү булчирхайн хэмжээнээс
 - E. Сийвэнгийн креатинины төвшингөөс
- /46./ Панкреонекрозын үед хийгддэг Секвестрэктоми гэж юуг хэлэх вэ?
- A. Цуллаг эрхтэний цусан хангамжгүй болсон эдийг авах мэс заслын арга
 - B. Орчны эдээс бүрэн салсан цусны судастай ямар ч холбоогүй үхэжсэн эдийг авах мэс заслын арга
 - C. Үхэжсэн нойр булчирхайн гадуур бүрхсэн хальсыг зүсэж авах мэс заслын арга
 - D. Панкреонекрозын үед зайлшгүй хийгддэг нойр булчирхайг хэвлийд ил гаргах мэс заслын арга
 - E. Бага сэмжний зайд хуримтлагдсан үхэжсэн эд, идээ, үрэвслийн шингэнийг авах, цэвэрлэх арга
- /47./ Цусаар түгсэн остеомиелитийн үед ясны аль хэсэг хамгийн түрүүнд гэмтдэг вэ?
- A. Өсөлтийн зурвас
 - B. Эпифиз
 - C. Диафиз
 - D. Метафиз
 - E. Диафиз ба эпифиз
- /48./ Фурнье –Гангрена нь хуйхнагт ямар шинж тэмдэг үүсгэх вэ?
- A. Өвдөлт
 - B. Ялгаралт
 - C. Шаржигнуур
 - D. Арьс улайх
 - E. Хавдах
- /49./ Гэдэсний түгжрэлийн үед илрэх шинжүүдийг харгалзуул.
1. Клойберийн аяга
 2. Хийн хоолойн шинж
 3. Валягийн шинж
 4. Кивулягийн шинж
- A. Чинэрсэн гэдэсний гогцоо олгой шиг тэмтрэгдэх
 - B. Чинэрсэн гэдэсний гогцоо дээр тогшиход хэнгэргэн чимээ гарах
 - C. Рентгенд хийгээр дүүрч чинэрч тахийсан, босоо гэдэсний гогцоо харагдах
 - D. Рентгенд гэдэсний аль нэг хэсэгт шингэний түвшин дээр нь аяга хөмөрсөн юм шиг хий тогтсон байх
- A. 1A,2B,3D,4C
 - B. 1B,2A,3D,4C
 - C. 1C,2A,4D,4B
 - D. 1D,2B,3A,4C
 - E. 1D,2C,3A,4B
- /50./ Мухар олгой шүүрэл ялгаруулагч эрхтэн бөгөөд нэг цагт хэдэн мл шүүрэл ялгаруулдаг вэ?
- A. 0,8-3,5 мл
 - B. 1,0-1,2 мл
 - C. 0,2-0,5 мл
 - D. 4,0 мл
 - E. 0,2 мл
- /51./ Өрцний ивэрхийн (Hiatal hernia) элбэг тохиолдох хэлбэр юу вэ

- A. 1-р хэлбэр
- B. 2-р хэлбэр
- C. 3-р хэлбэр
- D. 4-р хэлбэр
- E. 2 ба 4-р хэлбэр

/52./ Анхдагч шарх эдгэрэлтийн үе шатуудыг харгалзуул.

- 1. Үрэвслийн үе
- 2. Төлжлийн үе
- 3. Хөрсжих, сорвижих үе

- A. Эд эсийн задралын бүтээгдхүүн татарч, шархны шүүдэс багасч, мөхлөг эдийн ургалт эхлэх
- B. Шарханд эд, эсийн задралын бүтээгдхүүн үүсч, гистамин, серотонин хуралдаж улмаар нэвчис, шүүдэс хуралдана
- C. Мөхлөгт эд нь хучуур эдээр бүрхэгдэж, бэхжиж эхлэнэ

- A. 1C,2A,3B
- B. 1A,2B,3C
- C. 1B,2A,3C
- D. 1B,2C,3A
- E. 1C,2B,3A

/53./ Мухар олгойн угийг боож тайрсны дараа X хэлбэрийн оёдол тавьж, угийг чихэх арга хэний арга вэ?

- A. Вишневскийн арга
- B. Жьюварагийн арга
- C. Риделийн арга
- D. Добарна-Дьяконовийн арга
- E. Понсейн арга

/54./ Олонхи судлаачид гэдэсний механик түгжрэлийг үндсэн үеүүдэд хувааж үздэг. Эдгээрээс аль нь вэ?

- 1. Гэдэсний хөдөлгөөн ихсэх үе
- 2. Гэдэсний хөдөлгөөн багасах үе
- 3. Саажилтын үе
- 4. Гэдэсний үечилсэн агшилт алдагдах үе
- 5. Гэдэсний хэсэгчилсэн саажилт үүсэх үе

/55./ Ходоод дээрх гэдэсний шархлааны мэс заслын эмчилгээний харьцангуй заалтыг нэрлэ

- 1. Эмийн эмчилгээнд 1,5 жилийн хугацаанд эдгэрээгүй шархлаа
- 2. Эмийн эмчилгээ үр дүнгүй байгаа цус алдалт, бөөлжилт, өвдөлт
- 3. Нэвчдэст ба каллез болсон 6 сарын эмийн эмчилгээнд үр дүнгүй шарх
- 4. Хагалгааны дараа дахисан шархлаа
- 5. Олон тооны том /аварга/ гүнзгий шархлаа

/56./ Мезоцекаль байрлалтай цочмог аппендицитийн үед аль шинжүүд илүү чухал оношлогооны ач холбогдолтой байдаг вэ?

- 1. Хэвлийгээр нэлэнхүйдээ өвдөнө
- 2. Булчин чангарал, гялтан цочролын шинж тод илэрнэ.
- 3. Олон удаа чацга алдаж, гэдэс дүүрнэ
- 4. Симптом Горно илэрнэ.
- 5. Симптом Гуревич илэрнэ.

/57./ Өвдөг, түнхний үенд хиймэл үе суулгах хагалгааны хожуу үеийн хүдрэлүүд аль нь вэ?

- 1. Суулгац ховхрох
- 2. Контрактур үүсэх
- 3. Хиймэл үений хугарал
- 4. Харшил
- 5. Цус алдалт

/58./ Цочмог аппендицитийн үе дэхь хэвлийн дотоод даралт ихсэх хам шинжийн шалтгааныг нэрлэнэ үү?

- 1. Гэдэсний хана хавагнан зузаарч, хэт тэлэгдэл үүсэх

2. Хэвлийн хөндийд шингэн хэт их хуримтлагдах
 3. Хэвлийн өмнөд болон хажуу хана хэт хөшингө болох, өвчин намдаалт хангалтгүй байсантай холбоотой булчингийн чангарал удаан үргэлжлэх
 4. Гялтангийн арын идээт процесс бий болох
 5. Хэвлий болон аарцгын уйланхай, кистома, бэтэг өвчинтэй холбоотой
- /59./ Бэтэг өвчнийг ямар эмээр эмчилбэл зохистой вэ?
1. Метронидазол
 2. Альбендазол
 3. Вермокс
 4. Мебендазол
 5. Себастазол
- /60./ Цочмог панкреатитын үед дараахь ферментүүдээс аль нь ялгаралт болон үйл идэвхиждэг вэ?
1. Трипсин
 2. Химотрипсин
 3. Эластаза
 4. Липаза
 5. Коллагеназа
- /61./ Шамбарам өвчний эмгэг жам дараахь үе шаттай.
1. Өвчний эхлэл үе
 2. Гемодинамикийн өөрчлөлт
 3. Хүндрэлийн үе
 4. Дистрофийн өөрчлөлт
 5. Томрох үе шат
- /62./ Безоарын ямар ямар төрлүүд байдаг вэ?
1. Фитобезоар
 2. Шеллакобезоар
 3. Себобезоар
 4. Пиксобезоар
 5. Лактобезоар
- /63./ Цочмог панкреонекрозын үед төлөвлөсөн угаалга, некроэктоми, секвестрэктомиг ямар давтамжит хугацаанд хийвэл зохистой байдаг вэ?
1. Өдөр бүр хийх хэрэгтэй
 2. Өнжөөд төлөвлөсөн угаалгыг хийх нь зөв
 3. Долоо хоногт нэг хийх нь зөв
 4. 48-96 цагийн зайтай хийх нь зөв
 5. Гурав хоног дутам угаалга хийнэ
- /64./ Гэдэсний түгжрэлийн хөдөлгөөн багасах үед ямар эмнэлзүйн шинж илрэх вэ?
1. Бөөлжих
 2. Судасны цохилт олшрох
 3. Чагнахад гэдэсний гүрвэлзэх чимээ сонсогдоно.
 4. Тэмтрэлтээр хэвлийн өмнөд хана эмзэглэлтэй
 5. Халуурах
- /65./ Мухар олгойн нэвчдэсийн тавилан ямар байдаг вэ?
1. Нэвчдэс зэргэлдэх эрхтэнүүдтэй наалддаг тавилантай
 2. Нэвчдэс шимэгдэж эдгэрдэг сайн тавилантай
 3. Нэвчдэс цоорох хүндрэл үүсгэдэг тавилантай
 4. Нэвчдэс идээлж хүндэрдэг тавилантай
 5. Нэвчдэс хөндийд эрхтэн рүү цоордог тавилантай
- /66./ Фолликулитийг үсний уутанцарыг хэрхэн гэмтээж байгаагаар нь хэрхэн ангилах вэ?
1. Остеофолликулит
 2. Өнгөц фолликулит
 3. Гүн фолликулит
 4. Дерматофитфолликулит
 5. Боксрадын фолликулит
- /67./ Lamina superficialis fascii colli propria ямар булчингуудыг хучиж уут үүсгэдэг вэ?

1. m.platysma
2. m.trapezeus
3. m.omohyoideus
4. m.sternocleidomastoideus
5. m.sternohyoideus

/68./ Шамбарам өвчний аль үе зэргийн үед эмийн эмчилгээг хийх вэ?

1. Хурц шамбарамын 2-3 зэрэг
2. Архаг шамбарамын 3-4 зэрэг
3. Хурц шамбарамын 1,2,3 зэрэг
4. Архаг шамбарамын 1-2 зэрэг
5. Зөвхөн хурц шамбарамын 1 зэрэгт

/69./ Ретроцекаль байрлалтай аппендицитийн үед аль шинж илүү чухал вэ?

1. Симптом Образцова
2. Симптом Яуре-Розанова
3. Симптом Варламова
4. Симптом Пунина
5. Симптом Габая

/70./ Хиймэл суулгацын титаниум нитрид (TiN) бүрхүүлийн давуу тал аль нь вэ?

1. Биологийн таарамж сайн
2. Хатуулаг чанар маш өндөр
3. Гадаргуугын хорогдол маш бага
4. Үений шингэнтэй зохицох чанар өндөр
5. Удаан хугацаанд химийн шинжээ алдахгүй

/71./ Мухар олгой авах хагалгааны дараах хүндрэлд аль аль орох вэ?

1. Цус алдах
2. Цусан хураа үүсэх
3. Оёдлын идээт цорго үүсэх
4. Шарх идээлэх
5. Гэдэсний цорго үүсэх

/72./ Өрцөн доорхи буглааны үед дараахь шинжүүд оношлогооны чухал ач холбогдолтой байдаг.

1. Баруун плеврийн хөндийд шингэн байгаа нь тодорхойлогдоно.
2. Өрцний дор хий шингэний хөндлөн төвшин рентгенд харагдана.
3. Симптом Троянова тод илэрнэ.
4. Цээжний баруун талаар өвдөж, гүнзгий амьсгалахад хөндүүрлэнэ
5. Өрцөн дор хадуур хэлбэрийн хий тодорхойлогдоно

/73./ Дээрх гэдэсний хэсгүүдийг нэрлэ

1. Pars superior
2. Pars descendens
3. Pars horizontalis
4. Pars ascendens
5. Pars intermuralis

/74./ Хиймэл үе суулгах хагалгааны харьцангуй эсрэг заалт аль нь вэ?

1. Биеийн жингийн индекс 30-с дээш байх
2. Элэгний хатуурал
3. 80-с дээш нас
4. Урьд нь хиймэл үе суулгах хагалгаанд орж байсан
5. Антибиотикт харшилтай байх

/75./ Цочмог аппендицитийн хүндрэлд аль нь хамрагдах вэ?

1. Мухар олгойн нэвчдэс
2. Мухар олгой орчмын буглаа
3. Өрцөн доорхи буглаа
4. Аарцгын буглаа
5. Гэдэсний гогцоо хоорондын буглаа

/76./ Цусны ямар элементэд агглютинин байдаг вэ?

1. Ялтаст эс

2. Цагаан эс
3. Улаан эс
4. Сийвэн
5. Аварга эс

/77./ Spatium retroviscerale-д идээтэй бол хаагуур зүслэг хийж идээг гаргах вэ?

1. Баруун талын m.sternocleidomastoideus-ын урд ирмэгтэй зэрэгцээ зүслэг хийж идээг гаргана.
2. Зүүн талын m.sternocleidomastoideus-ын доод хэсэгт зэрэгцээ зүслэг хийж идээг гаргана.
3. Баруун талын m.sternocleidomastoideus-ын ард ирмэгтэй зэрэгцээ зүслэг хийж идээг гаргана.
4. Зүүн талын m.sternocleidomastoideus-ын урд ирмэгтэй зэрэгцээ зүслэг хийж идээг гаргана.
5. Баруун талын m.sternocleidomastoideus-ын урд ирмэгтэй хөндлөн зүслэг хийж идээг гаргана.

/78./ Цавины ивэрхийг ямар өвчнөөс ялган оношлодог вэ?

1. Гидроцеле
2. Варикоцеле
3. Төмсөг мушгирах
4. Цавины тунгалгын булчирхайн цочмог үрэвсэл
5. Орхит

/79./ Аппендэктоми хагалгааны дараа ойролцоогоор хэд дэхь хоногт аарцгын буглаа үүсэх нь элбэг байдаг вэ?

1. 3 дахь хоногт
2. 14 дэхь хоногт
3. Нэг сарын дараа
4. 5-7 дахь хоногт
5. 10-14 дэхь хоногт

/80./ Омфалитийн үед ямар шинж нярайд илрэх вэ?

1. Хүйс орчим хавагнах
2. Хүйс улайж эмзэглэлтэй болох
3. Идээрхэг шүүдэс хүйнээс гарах
4. Гэдэс дүүрэх
5. Хүүхэд уур уцаартай болох

/81./ Ваготоми буюу тэнэгч мэдрэл таслах хагалгаа ямар төрлүүдтэй байдаг вэ?

1. Ишэлсэн ваготоми
2. Сонгомол ваготоми
3. Захалсан сонгомол ваготоми
4. Ишэлсэн сонгомол ваготоми
5. Сонгомол захалсан ваготоми

/82./ Цочмог панкреатитийн үеийн гялтангийн ар хэсэгт нэвчээс үүсэх онцлог дараахь хэлбэрүүд байдаг.

1. Идээт нэвчээсийн баруун хэлбэр
2. Идээт нэвчээсийн төвийн хэлбэр
3. Идээт нэвчээсийн зүүн хэлбэр
4. Идээт нэвчээсийн холимог хэлбэр
5. Идээт нэвчээсийн сонгомол хэлбэр

/83./ Цочмог парапроктит өвчний гүн байрлалтай хэлбэр нь:

1. Арьсан доорх
2. Бага аарцаг шулуун гэдэсний
3. Салстын доорх
4. Суудал яс шулуун гэдэсний
5. Арьсан доорх тах хэлбэрийн

/84./ Ясны өсөлтийн зурвас ясны яль хэсэгт байрладаг вэ?

- А. Диафиз
- В. Метафиз

- C. Эпифиз
- D. Ясны хэмт хэсэг
- E. Эпифиз болон ясны хэмт хэсэг

/85./ Ходоодны G эс ямар шүүрэл ялгаруулах вэ?

- A. Гастрин
- B. Бомбезин
- C. Соматостатин
- D. Гистамин
- E. Пепсиноген

/86./ Давсаг үтрээний цоорхой үүсэх үндсэн шалтгаан

- A. Өгзөг байрлалтай төрөлт
- B. Шээсний замын архаг үрэвсэл
- C. Эмэгтэйчүүдийн хагалгааны үеийн гэмтэл
- D. Давсаг хярзангийн эдийн тэжээлийн алдагдал
- E. Эмэгтэйчүүдийн хагалгааны дараа шээс хаагдах

/87./ Мэс заслын халдвар үүсгэх эрсдэлд аль нь орохгүй вэ?

- A. Туяаны нөлөө
- B. Давтан мэс засал
- C. Нярай
- D. Эмнэлгийн ор хоног удааширсан
- E. Боолт эмчилгээ хангалтгүй

/88./ Нарийн гэдэсний түгжрэлийн зонхилох шалтгаан юу вэ?

- A. Наалдац
- B. Ивэрхий
- C. Хорт хавдар
- D. Кроны өвчин
- E. Нарийн гэдэсний шархлаа

/89./ Аль нь арьсны хүрцээр бөөрний чулуу авах мэс заслын эхний шат вэ?

- A. Бөөр рүү хатгалт хийх
- B. J-гуурс байрлуулах
- C. Шээлгүүрт гуурс байрлуула
- D. Венийн судсанд тодотгогч бодис хийх
- E. Бөөрөнд гуурс тавих

/90./ Дараах ходоодны ургацагуудаас аль нь хорт хавдарын урьдал вэ?

- A. Хамартоматоз
- B. Аденоматоз
- C. Гетеротопик
- D. Үрэвслийн
- E. Бүгд

/91./ Мухар олгойн шүүрлийн рН хэд байдаг вэ?

- A. 5,2-6,4
- B. 6,2-7,8
- C. 8,0
- D. 8,3-8,9
- E. 9,0-9,4

/92./ Элэгний бэтэг өвчний үед хэт авиан шинжилгээнд заримдаа цас будрах өвөрмөц шинж гардаг. Уг шинж элэгний бэтэг өвчний ямар хэлбэрийг оношлох вэ?

- A. Шохойжсон бэтэг
- B. Идээлсэн бэтэг
- C. Залуу бэтэг
- D. Үр уйланхайгүй бэтэг
- E. Хөгшин бэтэг

/93./ Бөөрний буглааг оношлоход мэдрэг шинжилгээг нэрлэнэ үү?

- A. Хэт авиан шинжилгээ
- B. Индий бодистой зураг авах
- C. Ганий бодистой зураг авах

D. Ялгаруулах шээс дамжуулах замын зураг авах

E. Комьпютер томографи

/94./ Шамбарам өвчин гэж юуг хэлэх вэ?

A. Венийн судасны өргөсөлт өвчин

B. Судаслаг хөвсгөр биетийн томролт

C. Цусны их эргэлтийн хямрал

D. Шулуун гэдэсний салстын өвчин

E. Судаслаг хөвсгөр биетийн жижгэрэл

/95./ Цавины сувгийн бүтэц, ханыг харгалзуул.

1. Урд хана

2. Арын хана

3. Доод хана

4. Дээд хана

A. Хэвлийн хөндлөн хальс

B. Цавины холбоос

C. Хэвлийн гадна ташуу булчингийн шөрмөсөн хальс

D. Хэвлийн шулуун болон дотор ташуу булчингийн доод ирмэг

A. 1B,2A,3C,4D

B. 1C,2A,3B,4D

C. 1A,2C,3B,4D

D. 1D,2A,3C,4B

E. 1C,2D,3A,4B

/96./ Остеомиелитийн үед рентген зурагт хамгийн түрүүнд илрүүлж болох шинж аль нь вэ?

A. Хэсэг газрын ясны сийрэгжилт

B. Ясны хальсны зузаарал

C. Цоохортсон склероз

D. Ууссан хэсэг

E. Ясны хальсны зузаарал ба цоохортсон склероз

/97./ Залгиурын доод зайнаас эхлэх цагаан мөгөөрсөн хоолойн дундаж урт?

A. 7 – 8 см

B. 10-13 см

C. 14-16см

D. 20-24 см

E. 25см-с дээш

/98./ Тархмал хордлогот бахууд мэс засал хийхдээ үлдээх булчирхайг хаана үлдээдэг вэ?

A. Бамбай булчирхайн дээд дэлбэнд

B. Бамбай булчирхайн доод дэлбэнд

C. Цагаан мөгөөрсөн хоолой, улаан хоолойн ховилд

D. Улаан хоолойн хажуу хананд

E. Цагаан мөгөөрсөн хоолойн хажууд

/99./ Гэдэсний цоорхой аяндаа битүүрэх явц ямар нөхцөлд удаашрах вэ?

A. Туяанд өртөх

B. Альбумины түвшин 4-с бага

C. Цоорхойн суваг 2 см –с урт

D. Цоорхойн суваг эпителизацигүй

E. Гэдэсний хана нэвчдэс ихтэй

/100./ Түүрүү булчирхайн шингэнд хэвийн үед цагаан эс хэд байх вэ?

A. 0-1-6

B. 10-15

C. 20-25

D. 25-100

E. 100-200

/101./ Цавины ивэрхийн уутанд байрлах шингэнийг юу гэж нэрлэдэг вэ?

A. Ивэрхийн ус

B. Орхитийн шингэн

С. Үрэвслийн шингэн

D. Экссудат

E. Транссудат

/102./ Элэгний бэтгийн мэс заслын аргуудыг харгалзуул

1. хагас задгайлсан эхинококкэктоми

2. Марсупиелирация

3. Сонгомол эхинококкэктоми

A. Бэтгийн уйланхайг гадна фиброз бүрхүүлтэй нь авах

B. Бэтгийн уйланхай хожим идээлж болох сэжигтэй байвал фиброз бүрхүүлийг бэтгийн тогтоцыг авсны дараа хэвлийн урд ханаруу сойж оёох

C. Фиброз бүрхүүлийн хөндийг антисептик уусмалаар угааж ариутгасны дараа хөндийд гуурс байрлуулж, хөндийг багасгаж оёох

A. 1A,2C,3B

B. 1A,2B,3C

C. 1B,2A,3C

D. 1C,2A,3B

E. 1C,2B,3A

/103./ Цээжний гуурсаар өдөрт 1000 мл шингэн гарч буй хилиоторакстай өвчтөн өдөрт ямар хэмжээний уураг алдах вэ?

A. 10-15 гр

B. 25-50 гр

C. 70-85 гр

D. 100-120 гр

E. 150-с дээш

/104./ Дараах эрхтнүүдийн аль нь хагалгааны дараах саажлын байдлаас удаан гардаг вэ?

A. Ходоод

B. Дээрх гэдэс

C. Өлөн гэдэс

D. Бүдүүн гэдэс

E. Саажил аяндаа арилдаг

/105./ Элэгний бэтгийн үед дараахь аргуудаар мэс засал эмчилгээ хийнэ. Эдгээр аргуудыг тайлбартай нь тохируулан сонго. 1. Хагас задгайлсан эхинококкэктоми 2. Марсупиелизаци 3. Сонгомол эхинококкэктоми 4. Эхинококкэктоми а. Бэтгийн хөндийг фиброз бүрхүүлээр нь устгах б. Бэтгийн хөндийг антисептик уусмалаар угааж, хяналтын гуурс үлдээх, хөндийг багасгаж оёх в. Бэтгийн уйланхай элэгний эдтэй бага газраар нийлсэн тохиолдолд бэтгийн уйланхайг гадна фиброз бүрхүүлтэй нь мулзалдаг арга г. Фиброз бүрхүүлийг бэтгийн тогтоцыг авсны дараа хэвлийн урд хана руу сойж оёх

A. 1а 2б 3в 4г

B. 1б 2в 3а 4г

C. 1б 2г 3в 4а

D. 1в 2б 3в 4а

E. 1в2а3б4г

/106./ Плеврт эмгэг шингэнтэй үед байнгын гуурс хэрэглэх эхний заалт юу вэ?

A. Уушгины тэлэгдэлт муу байх

B. Амьдрах чадварыг уртасгах

C. Плеврийн шингэн идээрхэг, үнэртэй байх

D. Цусны Д-даймер шинжилгээ эерэг байх

E. Өвчтөний биеийн байдал сайжрахгүй байгаа

/107./ Мухар олгой авах дурангийн хагалгааны заалт юу вэ?

A. Арын байрлалтай үрэвссэн мухар олгойтос

B. Улаймал үрэвсэл буюу хөнгөн хэлбэрийн баалсан үрэвсэлтэй байх

C. Ойр орчимдоо нэвчдэстэй хөдөлгөөнгүй мухар олгой

D. Хэсгийн гятангийн үрэвсэлтэй байх

E. Дурдсан шинжүүд бүгд зөв

/108./ Ходоод-гэдэсний замын стромын /GIST-gastrointestinal stromal tumors/ хавдрууд ихэвчлэн хаана байрладаг вэ?

- A. Ходоод
- B. Дээрх гэдэс
- C. Өлөн гэдэс
- D. Цутгалан гэдэс
- E. Бүдүүн гэдэс

/109./ Идээлүүлэгч нян дараахь замуудаар элгэнд нэвтрэн ордог бөгөөд шалтгаан болон дамжих замуудыг уялдуулан сонго. 1. Үүдэн венээр

- 2. Цөсний замаар
- 3. Хавьтлаар халдварлах
- 4. Артерийн замаар
- 5. Элэгний өөрийн өвчнөөс
- a. Хэвлийн гялтангийн үрэвсэл, цочмог аппендицит, ходоодны цоорсон шархлаа гэх мэт идээт үрэвсэлт өвчний үед
- б. Цөсний идээт үрэвсэл, гэдэсний шархлаа элэг рүү нэвчиж цоорсноос
- в. Идээт холангит болсны улмаас
- г. Хавдар, усан уйланхай болон элэгний бусад голомтот эмгэг буглаж, халдварлагдсанаас
- д. Ясны идээт үрэвсэл, үжил зэрэг цусан үжилт идээт өвчний улмаас
- A. 1а 2б 3в 4г 5д
- B. 1б 2в 3д 4г 5а
- C. 1а 2д 3б 4г 5в
- D. 1а 2в 3б 4д 5г
- E. 1д2а3б4в5г

/110./ Ивэрхийн уутанд байрласан мухар олгойн хэлбэрүүдээс аль нь харьцангуй аюул багатай вэ?

- A. Мухар олгой бүхэлдээ ивэрхийн уутанд байрласан
- B. Мухар олгойн үзүүр хэсэг ивэрхийн уутанд, үлдсэн хэсэг нь хэвлийн хөндийд байрласан
- C. Мухар олгойн үзүүр хэсэг хэвлийн хөндийд, уг хэсэг нь ивэрхийн уутанд байрласан
- D. Мухар гэдэс мухар олгойн хамт ивэрхийн уутанд хамт орсон байх
- E. Дурдсан шинжүүд биш

/111./ Хагалгааны дараа гэдэсний саажилыг багасгахад аль нь илүү үр дүнтэй вэ?

- A. Хамраар ходоодонд байрлуулсан гуурсаар соруулга хийх
- B. Шингэн сэлбэх
- C. Эрт хооллох
- D. Шулуун гэдсээр лаа хийх
- E. Шулуун гэдсээр клизм тавих

/112./ Гэмтэлтэй өвчтөнд цээжний мэс засал хийвэл ямар хүрц сонгох вэ?

- A. Босоо стернотом
- B. Цээжний дурангийн мэс засал
- C. Ар хажуугийн торакотом
- D. Урд хажуугийн торакотом
- E. Аль нь ч биш

/113./ Дараахь элэгний эмгэгүүдийг үүсгэгчтэй нь харьцуулан тохируул

- 1. Элэгний буглаа
- 2. Элэгний бэтэг
- 3. Элэгний молцгон уйланхай
- 4. Элэгний олдмол усан уйланхай
- a. *Echinococcus granulosus*
- б. Анхдагч болон хоёрдогч халдвар орсноос
- в. *alveococcus multilocularis*
- г. Глиссон хальс, эдийн завсраар цус хурснаас
- A. 1а 2б 3в 4г
- B. 1б 2а 3в 4г
- C. 1в 2г 3а 4б

D. 1а 2в 3б 4г

E. 1г2а3б4в

/114./ Нас бие гүйцсэн эмэгтэй хүний хөхний булчирхайд хэдэн хэсэг байдаг вэ?

A. 5-10

B. 15-20

C. 25-30

D. 35-40

E. 45-с дээш

/115./ Гэдэсний түгжрэлийн ангилал ба механизмыг харгалзуулан сонго. 1. Бөглөрлийн түгжрэл

2. Боймолсон түгжрэл

3. Динамик түгжрэл

4. Наалдацт түгжрэл

5. Хавсарсан түгжрэл

а. Гэдэсний нэг хэсэг нөгөө хэсэг рүү чихэлдэх

б. Гэдэсний аль нэг хэсгийн хүчтэй агшилт

в. Бүдүүн гэдэсний хавдар гэдэсний хөндийг нарийсгах

г. Гэдэсний гогцоо тэнхлэгээ дагаж эргэх

д. Гялтан хальсны наалдацын улмаас үүссэн түгжрэл

A. 1а 2б 3в 4г 5д

B. 1б 2в 3д 4г 5а

C. 1в 2г 3б 4д 5а

D. 1а 2в 3б 4д 5г

E. 1г 2а 3в 4д 5б

/116./ Шамбарам өвчнийг хэдэн зэрэг болгон ангилах вэ?

A. 3

B. 4

C. 5

D. 2

E. 6

/117./ Элэгний бэтэг элэгний аль хэсэгт ихэвчлэн байрласан байдаг вэ?

A. Элэгний баруун дэлбэнд

B. Элэгний зүүн дэлбэнд

C. Элгийг бүхэлд нь хамарна

D. Элэгний төв хэсэгт

E. Өрцөн дор

/118./ Трихобезоар гэж юуг нэрлэх вэ?

A. Ургамлан голтой безоар

B. Ходоодонд үс бөөнтөх

C. Амьтны гаралтай өөх тосноос үүссэн безоар

D. Давирхай зажлахаас шалтгаалж үүсдэг

E. Шүлтлэг найрлага бүхий безоар

/119./ Түрүү булчирхайн хорт хавдартай өвчтөнд ямар тохиолдолд хүлээх тактик баримтлах вэ?

A. Глисоны үнэлгээ 10-с дээш

B. Нас 55-с бага

C. Голомтын хэмжээ эдийн шинжилгээ авах боломжгүй бага

D. Түрүү булчирхайн өвөрмөц маркер 35-с бага

E. Дээрхийн аль нь ч биш

/120./ Насанд хүрсэн хүний хэвлийн дотоод даралт хэвийн үед ямар хэмжээтэй байх вэ?

A. 5-7 мм.м.у.б

B. 10 мм.м.у.б

C. 40 мм.м.у.б

D. 2 мм.м.у.б

E. 30 мм.м.у.б

/121./ Бөөрний хөхлөгийн некроз үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл аль нь вэ?

- A. Дутагдал
- B. Абсцесс
- C. Бөглөрөл
- D. Чулуу
- E. Хавдар

/122./ Меккелийн цүлхэн мухар гэдэс, нарийн гэдэсний уузвараас хэдэн см зайд байрладаг вэ?

- A. 40-50 см
- B. 1 метр
- C. 15-20 см
- D. 70-80 см
- E. 2 метр

/123./ Дараах судсуудын аль нь улаан хоолойн цусан хангамжид оролцдоггүй вэ?

- A. Бамбайн доод артери
- B. Бронхийн артери
- C. Ходоодны баруун артери
- D. Өрцний доод артери
- E. Дүрдсан судсууд бүгд оролцоно

/124./ Гэдэсний саатлын буюу механик түгжрэлийг бөглөрлийн төвшингийн хувьд хэрхэн хувааж үздэг вэ?

- 1. Нарийн гэдэсний
- 2. Дээгүүр байрлалтай
- 3. Хос гэдэсний
- 4. Доогуур байрлалтай
- 5. Бүдүүн гэдэсний

/125./ Цочмог парапроктит өвчин нь хошногоны булчирхайнаас үүдэлтэй. Эдгээр булчирхай нь ихэвчлэн:

- 1. Морганы хуниас дотор
- 2. Шулуун гэдэсний эслэгт
- 3. Шулуун гэдэсний төгсгөл хэсгийн салстын доорх давхаргад
- 4. Дотор хуниас булчингийн гүнд
- 5. Гадна хуниас булчингийн гүнд

/126./ Цавины ивэрхийн хүндрэлд аль нь орох вэ?

- 1. Ивэрхийн үрэвсэл
- 2. Ивэрхий буцаж орохгүй байх
- 3. Баас хатах
- 4. Гэдэсний гогцоо хуухнагт орох
- 5. Ивэрхий орчим өвдөх

/127./ Хэт авианд мухар олгойн үрэвслийг батлах дараахь шинжүүд байдаг.

- 1. Мухар олгойн голч 0,6 см –ээс илүү болох
- 2. Мухар гэдэс, цутгалан гэдэс орчим шингэн үүсгэвэр тодорхойлогдох
- 3. Цутгалан орчмын өөхөн эдийн нягтрал ихсэж, ямар нэг хэмжээний нэвчдэст өөрчлөлт илрэх
- 4. Хэт авиан шинжилгээний даралтат сорилд мухар олгойн хэлбэр өөрчлөгдөх
- 5. Мухар олгойн хөндийд хий тодорхойлогдох

/128./ Шамбарам өвчний шинж тэмдгийг нэрлэ.

- 1. Загатнах /хошног/
- 2. Өвдөх /хошног/
- 3. Дүлүүлэх
- 4. Цус гарах /хошног/
- 5. Халуурах

/129./ Хиймэл үений үндсэн шинж чанарууд аль нь вэ?

- 1. Хүний биед харшил төрүүлэхгүй
- 2. Тухайн үений анатомийн хэлбэрийг хадгалах
- 3. Бат бөх чанар, хэлбэр дүрсээ удаан хугацаанд хадгалах
- 4. Зэвэрдэггүй байх

5. Тухайн үений физиологийн үүргийг хангах
- /130./ Мухар олгой гүрвэлзэх хөдөлгөөн хийх чадвартай эрхтэн юм. Мухар олгойн булчингийн давхарга дотроо ямар ямар булчингийн ширхэгүүдтэй байдаг вэ?
1. Жишүү
 2. Дагуу
 3. Хөндлөн
 4. Цагираг
 5. Туузан
- /131./ Архаг аппендицитийг эмнэлзүйн явцаар нь юу гэж ангилах вэ?
1. Улаймал архаг аппендицит
 2. Анхдагч архаг аппендицит
 3. Хоердогч архаг аппендицит
 4. Дахилтат архаг аппендицит
 5. Намжмал архаг аппендицит
- /132./ Жирэмсэн үеийн цочмог аппендицитийн үед аль шинж илүү чухал байх вэ?
1. Симптом Кохера –Волковича
 2. Симптом Гооша-Ичинхорло-Анаргула
 3. Симптом Московского
 4. Симптом Брендо
 5. Симптом Дъелафуа
- /133./ Мухар олгойн нэвчдэсийн /инфильтрат/ ямар ямар хэлбэрүүд байдаг вэ?
1. Зөөлөн нэвчдэс
 2. Идээлсэн нэвчдэс
 3. Хатуу нэвчдэс
 4. Хагарсан нэвчдэс
 5. Задарсан нэвчдэс
- /134./ Цусны ямар элементэд агглютиноген байдаг вэ?
1. Ялтаст эс
 2. Цагаан эс
 3. Улаан эс
 4. Сийвэн
 5. Аварга эс
- /135./ Ходоод дээрх гэдэсний шархлааны мэс заслын эмчилгээний туйлын заалтыг нэрлэ
1. Цоорсон шарх
 2. Дахилтат ба зогсохгүй, өөр аргаар тогтоож болохгүй цус алдалт
 3. Ходоодны гарах хэсэг, нугалуурын бүтэц алдагдсан сорвижилт
 4. Шархлааны улмаас хоол орохгүй болох, дамжуулалт алдагдах
 5. Шархлаа хорт хавдарт шилжих буюу малигнизаци болсон шархлаа
- /136./ Мухар олгойн нэвчдэсийг хаана байрласнаар нь дараах байдлаар хувааж үздэг.
1. Хэвлийн баруун доогуур байрласан нэвчдэс
 2. Мухар гэдэсний араар байрласан нэвчдэс
 3. Аарцгын хөндийд байрласан нэвчдэс
 4. Чацархайн синуст байрласан нэвчдэс
 5. Сэмжинд ороогдсон нэвчдэс
- /137./ Өвөрмөц парапроктит үүсэх шалтгаан нь:
1. Сүрьеэгийн савханцараар
 2. Актиномикозоор
 3. Тэмбүүгийн үүсгэгчээр
 4. Спор үүсгэдэггүй агааргүйтэн гэдэсний савханцар болон протейтэй хавсарсан
 5. Цус задлагч стрептококкоор
- /138./ Элэгний дотор хоригийн улмаас үүсэх үүдэн венийн даралт ихсэх хам шинж дараахь өвчнөөс шалтгаалж үүснэ.
1. Элэгний хатуурал
 2. Элэгний хавдар
 3. Элэгний фиброз хатуурал
 4. Элэгний уйланхай

5. Элэгний бэтэг

/139./ Цочмог панкреонекрозын үед бага сэмжний уутанд их хэмжээний үрэвслийн шингэн, идээ хурсан байх нь элбэг. Түүнийг юу гэж нэрлэдэг вэ?

1. Парапанкреатит
2. Хэвлийн хөндийн дээд давхаргыг хамарсан идээт үрэвсэл
3. Панкреатобилляр бүсийг хамарсан шүүдэст үрэвсэл
4. Оментобурсит
5. Секвестризацн панкреаса

/140./ Цочмог парапроктиттай өвчтөнд үзлэг хийж оношлоход хамгийн чухал нь:

1. Өвчилсөн хуниасны /крипт/ байршлыг зөв тодорхойлох
2. Нянгийн орчны онцлог
3. Идээт цоргоны хуниас булчинтай харьцах байдал
4. Идээт үрэвсэл тархсан байдал
5. Өвчилсөн хугацаа

/141./ Гэдэсний түгжрэлийн үндсэн гол шинжид аль нь хамаарагдах вэ?

1. Гэдэс базлаж өвдөх
2. Бөөлжилт
3. Хий, өтгөн хоригдох
4. Цардайх
5. Хэхрүүлэх

/142./ Түнхний үеийг хиймэл үеэр солих хагалгааны дараах хүндрэлүүдийг нэрлэнэ үү.

1. Халдвар
2. Гүний венийн тромбоз
3. Хиймэл үений мултрал
4. Суудлын мэдрэлийн саа
5. Суулгацын зэргэлдээх хугарал

/143./ Цочмог аппендицитийн хүндрэлд дараах төрлийн хүндрэлүүд орно.

1. Мухар олгойн нэвчээс
2. Мухар олгой орчмын буглаа
3. Гялтангийн арын идээт нэвчээс
4. Хэвлийн гялтангийн тархмал үрэвсэл
5. Мухар олгой цоорох

/144./ Цавины ивэрхийг ташуу болон шулуун ивэрхий гэж ангилдаг бөгөөд, ивэрхийн агуулагдахуун fossa inguinalis lateralis –р гарч байвал шулуун ивэрхий, fossa inguinalis medialis-р гарч байвал ташуу ивэрхий гэнэ

/145./ Архи нь нойр булчирхайн шүүсийг шингэлж , нойр булчирхайн цоргоны дотоод даралтыг эрс ихэсгэдэг учраас нойр булчирхайн шүүс гадагшлах явдлыг саатуулна .

/146./ Ходоодны шархлаа цоорсон үед хэвлийгээр маш хүчтэй өвдөнө. Учир нь ходоодны цусан хангамж алдагдсантай холбоотой.

/147./ Цөсний ерөнхий цоргонд чулуу байхыг холедохолитиаз гэх бөгөөд чулуу зөвхөн Фатеровын хөхлөгт шигдэн байрласан байдаг

/148./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн үед фосфолипаза фермент нойр булчирхай, түүний ойр орчмын эд, эсийн мембраныг задалдаг ба липаза фермент эсийн доторх триглицеридийг задалдаг учраас липолиз явагддаг.

/149./ Эмч үйлчлүүлэгчийг ЭХО –д харахад элгэнд дугуй хэлбэрийн нимгэн гэртэй, дотроо дүүрэн шингэнтэй бүтэц байсныг элэгний усан уйланхай гэж оношлоод альбендазол эмийг 400мг –р өдөрт 2 удаа 28 хоног, 14 хоногийн зайтай өдөрт 3 удаа давтан уухыг зөвлөжээ

/150./ Бэтгийн уйланхай томорч элэгний эд, судас, цөсний цоргыг шахан, глиссон хальс тэлсэн учраас эмнэл зүйд баруун сүврэгдэсээр өвдөх зовиур үүсэж эхэлдэг.

/151./ Амёбын гаралтай элэгний буглааны гол үүсгэгч нь entameoba hystolytica бөгөөд entameoba hystolytica нь ихэвчлэн бүдүүн гэдэснээс үүдэн венийн системээр дамжин элгэнд очиж элэгний буглааг үүсгэдэг байна.

/152./ Мухар олгойн цочмог үрэвслийн үед ходоод, аюулхай орчим хатгаж өвдөж эхэлдэг. Яагаад гэвэл ходоодонд их хий хуримтлагдана.

- /153./ Мухар олгойн хатуу нэвчдэсийн үед мэс заслын эмчилгээ эсрэг заалттай учраас эхэн үед нь эмийн эмчилгээ хийж, хүлээх тактик баримтлах хэрэгтэй.
- /154./ Үрийн сувгийг гадагш дээш нь татаж, зангилаат оёдлын тусламжтайгаар хэвлийн дотор ташуу болон хөндлөн булчингуудыг нэг мөсөн авч цавины холбоосонд бэхлэх аргыг Бассины арга гэх бөгөөд Бассины аргаар өндөр настай хүмүүсийн цавины ивэрхийг нөхдөг.
- /155./ Мухар олгой дахь эмгэг өөрчлөлт даамжиран мухар олгойг бүхэлд нь хамарч, их хэмжээний идээрхэг шингэн мухар олгойн хөндийд хуралдсанаас хана нимгэрч, уут хэлбэртэй болдог бөгөөд үүнийг мухар олгойн эмпием гэнэ.
- /156./ Echinococcus granulosus болон Alveococcus multilocalis хэмээх жижиг туузан хорхойнууд нь зөвхөн бэтэг өвчнийг үүсгэдэг учраас аль туузан хорхой нь бэтгийн үүсгэгч байхаас үл хамааран ЭХО –д илрэх шинж, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ нь ижил байна.
- /157./ Мухар олгойн цочмог үрэвслийн үе шатыг тодорхойлохдоо , мухар олгойд гарсан үрэвсэлт өөрчлөлтөөр нь ангилан үе шатыг тогтоох ба харин мухар олгойд гарсан эмгэг өөрчлөлт нь клиникийн илрэлийн тусгал нь болж чаддаггүй.
- /158./ Бүдүүн гэдэс түгжирэхэд шингэний түвшин хэвлийн хөндийн захаар байрлаж тоо ширхэгээрээ нарийн гэдэснийхээс олон байдаг. Яагаад гэвэл бүдүүн гэдэс олон тооны гогцоонуудтай.
- /159./ Нойр булчирхайг бүхэлд нь хамарсан үхжилтэй, бүдүүн гэдэсний өгсөх, уруудах болон хөндлөн хэсгийн араар болон баруун, зүүн бөөрний параколонг нилэнхүйд нь хамарсан нэвчээстэй байвал идээт нэвчээсийн төвийн хэлбэр гэх бөгөөд уг хэлбэр нь хамгийн хүнд явцтай байна.
- /160./ Ивэрхийн хүүдий дахь шингэнийг ивэрхийн ус гэх бөгөөд хавчигдсан гэдэсний артери вени 2 зэрэг дарагдвал ивэрхийн ус үүсч амжилгүй гэдэс үхжихийг хуурай үхжил гэнэ.
- /161./ Төрөлхийн болон олдмол цавины ивэрхий нь бүтцийн хувьд адил биш боловч нөхөх арга нь техникийн хувьд адилхан байна.
- /162./ Нойр булчирхайн архаг үрэвсэлийн үед баас цустай гарах шинж илэрдэг. Учир нь гэдэсний гогцоо тархмалаар өргөссөн байдаг.
- /163./ Цочмог панкреатитийн үед Мондорын гурвал шинж тод илрэнэ. Яагаад гэвэл наран сүлжээ цочирдог.
- /164./ Фатеровын хөхлөг цагираг, тууш, ташуу булчингийн ширхэгүүдээс тогтох учир дээрх гэдэсний булчингуудаас хамааралгүй ажилладаг.
- /165./ Ивэрхийн бүрдэл – ивэрхийн гарах нүх, ивэрхийн агуулагдахуун, ивэрхийн уут гэсэн 3 хэсгээс тогтох бөгөөд ивэрхийн бүрдэл гурвуул байвал жинхэнэ ивэрхий гэнэ.
- /166./ Гэдэсний хананд үүссэн хүүдий хэлбэрийн цүлхэнг дивертикулит гэх бөгөөд жинхэнэ, хуурамч гэж ангилдаг
- /167./ Чацархайн артерын тромбозын үед эмнэлзүй бүдэг аажим явцтай илэрдэг. Учир нь гэдэсний цусан хангамж алдагдахгүй.
- /168./ Мухар олгойн хана нь гэдэсний хананаас ялгарах онцлоггүй, адил төст бүтэцтэй байдаг бөгөөд сероз, булчин, салст бүрхүүлээс тогтоно.
- /169./ Хэвлийн гялтангийн тархмал идээт үрэвсэлийн /перитонит/ 2-р үед хэвлийн өвдөлт арай багасах ба Щеткина-Блюмбергийн илрэх нь бага зэрэг сулрах учраас гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн нэмэгдэнэ.

Сорилын зөв хариулт-Сорил-2

1-Е, 2-С, 3-С, 4-В, 5-В, 6-В, 7-С, 8-С, 9-С, 10-Д, 11-С, 12-Е, 13-А, 14-Д, 15-С, 16-Д, 17-Д, 18-Д, 19-В, 20-А, 21-В, 22-Д, 23-В, 24-С, 25-С, 26-Д, 27-А, 28-В, 29-Д, 30-С, 31-С, 32-Д, 33-С, 34-С, 35-В, 36-А, 37-С, 38-А, 39-В, 40-Д, 41-С, 42-А, 43-А, 44-Д, 45-Е, 46-В, 47-Д, 48-С, 49-Е, 50-А, 51-А, 52-С, 53-В, 54-А, 55-Е, 56-Е, 57-А, 58-Е, 59-С, 60-В, 61-С, 62-Е, 63-Д, 64-Е, 65-С, 66-А, 67-С, 68-Д, 69-Е, 70-Е, 71-Е, 72-В, 73-В, 74-А, 75-Е, 76-Д, 77-С, 78-В, 79-Д, 80-Е, 81-А, 82-В, 83-С, 84-В, 85-А, 86-С, 87-С, 88-А, 89-С, 90-В, 91-Д, 92-В, 93-Е, 94-В, 95-В, 96-А, 97-В, 98-С, 99-А, 100-А, 101-А, 102-Е, 103-В, 104-С, 105-С, 106-А, 107-В, 108-А, 109-Д, 110-А, 111-С, 112-Д, 113-В, 114-В, 115-С, 116-В, 117-А, 118-В, 119-С, 120-А, 121-С, 122-С, 123-С, 124-С, 125-Д, 126-А, 127-А, 128-В, 129-Е, 130-С, 131-С, 132-Д, 133-А, 134-Д, 135-Е, 136-А, 137-А, 138-

A, 139-D, 140-B, 141-A, 142-E, 143-E, 144-C, 145-D, 146-C, 147-C, 148-A, 149-B, 150-A, 151-A, 152-C, 153-A, 154-A, 155-A, 156-E, 157-C, 158-E, 159-D, 160-B, 161-C, 162-E, 163-C, 164-B, 165-A, 166-A, 167-E, 168-C, 169-B,